

ЕВРОПЫН ХОЛБООНЫ GSP PLUS ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД МОНГОЛ УЛСАД ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ, ТАЙЛАГНАХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХЭД НЬ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ (GSP+2)

2016.08.01-2019.01.31



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



НИЙГМИЙН ШУДАРГА ЕС
ЗОХИСТОЙ ХӨЛӨЛМӨР

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран “Европын холбооны GSP Plus хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, тайлагнах үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх төсөл (GSP+2)”-ийг 2016 оны 8 дугаар сарын 1-ээс 2019 оны 1 дүгээр сарын 31-ний хооронд хэрэгжүүлэв.

Энэхүү төсөл нь Монгол Улс дахь жижиг, дунд үйлдвэрүүдэд хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхүүдийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмрээ оруулах, түүний дотор:

- албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээ хийх эрхийг хангах, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар нийгмийн зөвшилцөл, хамтын хэлэлцээнд оролцох төлөөллийг сайжруулах чиглэлээр хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст ажилчдын зохион байгуулагдах болон хөдөлмөрлөх бусад үндсэн эрхийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлэхийг зорьсон юм.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХҮРЭЭНД

Европын Холбооны санхүүжилтээр 2015 оны 10 дугаар сарын 1-ээс 2018 оны 3 дугаар сарын 31-ний хооронд хэрэгжсэн “Олон улсын хөдөлмөрийн стандартын нийцэл, тайлагналтын үндэсний чадавхийг бэхжүүлэх замаар GSP-Plus статусыг тогтвортой хадгалах нь (GSP+1)” төслийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэхэд ОУХБ-аас үзүүлсэн дэмжлэгтэй энэхүү GSP+2 төслийн үйл ажиллагаа шууд уялдаатай хэрэгжсэн юм. Энэ хүрээнд нийгмийн зөвшлийн гурван талд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, гурван талт ажлын хэсгийн

үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үндэсний болон тусгайлсан хэлэлцүүлгүүд зохион байгуулахад хамтран ажилласан болно. Түүнчлэн Монгол Улсын нэгдэж орсон ОУХБ-ын конвенциудын хэрэгжилтийн тайланг гаргах, Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт дэд хорооны гишүүдийг мэдээллээр хангах, чадавхжуулах зорилгоор энэ асуудлыг хариуцсан олон улсын мэргэжилтнээр зөвлөгөө өгүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулав.

GSP+2 2017: Албан бус эдийн засагт ажиллагчдын эвлэлдэн нэгдэх болон хамтын хэлэлцээ хийх эрх

Албан бус эдийн засагт ажиллагчдын эвлэлдэн нэгдэх болон хамтын хэлэлцээ хийх эрх зүйн орчны шинжилгээгээр тэдний эрхээ хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн талаас шууд саад байхгүй боловч ажил олгогч болон ажилчдын аль аль нь төдийлөн зохион байгуулалтад ороогүй, төлөөлөл нь хязгаарлагдмал байна гэж дүгнэсэн. Үүнд тэдний хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэг дутмаг, эвлэлдэн нэгдэж, хамтын хэлэлцээ хийхийн зорилго, давуу талыг ойлгоогүй, гишүүнчлэлийн татвар төлөх чадваргүй зэрэг нь нөлөөлдөг байна.

Дэлгэрэнгүй үзэх:



<https://bit.ly/2RUDWuv>



<https://bit.ly/2SeUAUW>




2018 оны 5 дугаар сарын 23:
ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, нийгмийн түншүүдтэй хамтран зохион байгуулав. ОУХБ-ын Женевийн товчооны Хөдөлмөрийн хэм хэмжээний газрын Ахлах зөвлөх Тим Дэ Мэйэр “Хөгжиж буй орнуудын хөдөлмөрийн хуулийн шинэчлэл: Олон улсын түршлага” сэдвээр илтгэл тавьж оролцов.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2DEArPZ>



2018 оны 6 дугаар сарын 18:
ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ:
ХАМТЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР БА ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ЭРХ

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороотой хамтран “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл: Хамтын гэрээ, хэлэлцээр ба үйлдвэрчний эвлэлийн эрх” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Зөвлөлдөх уулзалтад үйлдвэрчний эвлэлийн удирдах ажилтнууд, аймаг, нийслэл, салбарын ҮЭ-ийн холбоодын төлөөлөл оролцож, хууль тогтоогчидтой санал бодлоо солилцож, шинэчлэлийн хүрээнд эвлэлдэн нэгдэх болон хөдөлмөрийн бусад үндсэн эрхүүдийг баталгаажуулах, өмнө хүрсэн түвшинг бууруулахгүй байх талаар байр сууриа илэрхийлэв.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2B8PXSG>




ХӨДӨЛМӨРИЙН ХҮРЭЭНИЙ СУУРЬ
ЗАРЧИМ, ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ СУУРЬ МЭДЭЭЛЛИЙГ
БҮРДҮҮЛЭХ ХҮРЭЭНД

2016-2017: “ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР ДЭХ
ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ:
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, НООС, НООЛУУРЫН
САЛБАР” СЭДЭВТ СУДАЛГАА

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс(ХЭҮК)-оос худалдаа, үйлчилгээ, ноос ноолуурын салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрүүдэд хөдөлмөрийн хүрээний суурь зарчим буюу эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, албадан хөдөлмөрийн бүх хэлбэрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, хөдөлмөр эрхлэлт дэх бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг зогсоох асуудлуудыг судалж, цаашид энэ хүрээнд нэн тэргүүнд анхаарч сайжруулах асуудлуудыг тодорхойлж зөвлөмж гаргав.


“Жижиг, дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа, үйлчилгээ, ноос, ноолуурын салбар” судалгааны тайлангаас...



Судалгаанд Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймгуудад худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбарт үйл ажиллагаа явуулж буй 200-аас доош тооны ажилтантай, бүртгэлтэй 78 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав.

Судалгааны үр дүнгээс харахад “албадан хөдөлмөр”-ийн хамгийн нийтлэг шинж болох ажилтны хувийн баримт бичиг, эсвэл цалинг ажил олгогчид барьцаа болгож авч байгаа тохиолдол илрэв. Судалгаанд оролцогчид “хүүхдийн хөдөлмөр” түн бага хувьтай байгааг хэлсэн бөгөөд судалгааны багтай тийм тохиолдол таарсангүй. Гэвч ажил олгогчид ажилтнуудынхаа насыг шалгаж авдаггүйгээс хүүхдийн хөдөлмөр байж болзошгүй байна. “Ажлын байран дахь дарамт” харьцангуй нийтлэг бөгөөд эмэгтэйчүүд, залуу ажилтнууд дарамтад илүүтэй өртдөг байдал ажиглагдав. Гэвч ажлын байран дахь дарамтын талаарх мэдлэг ойлголт дутмаг учраас ажилтнууд төдийлөн мэдээлдэггүй бөгөөд ажил олгогчийн





зүгээс мэдээлэх боломжийг олгоогүй байна.

Ажилтнууд “үйлдвэрчний эвлэл”-ийн үүрэг, ашиг тусын талаар тун бага ойлголттой байгаа бөгөөд ажилтнууд болон зарим ажил олгогчийн “хамтын хэлэлцээ, хамтын гэрээ”-ний тухай ойлголт хангалтгүй байна.

“Хөдөлмөрийн гэрээ”-г тогтмол байгуулдаг боловч ажилтанд нэг хувийг олгодоггүйн зэрэгцээ туршилтын хугацаагаар ажиллаж байгаа ажилтанд цалин хөлс олгохоос зайлсхийж байна. Ажил олгогчдын нэлээд хувь нь ажилтнууддаа “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ”-нээс доогуур цалин хөлс олгож байгаа нь ажиглагдсан бөгөөд ихэнх ажил олгогч ажилтнууддаа “ажил, амралт”-ын цагийг хуульд заасны дагуу олгохгүй байна.

Ажил олгогчдын ихэнх нь “ажлын байрны осол, гэмтэл”-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаггүй байна. Хуулийн дагуу бизнесийн байгууллагад “хөдөлмөрийн хяналт”-ын талаар урьдчилан мэдэгдэх ёстой байдаг нь ажил олгогчдод зөрчлөө нүүх боломжийг олгож байна.

Дэлгэрэнгүй үзэх:

<https://bit.ly/2FdZ3pD>



Судалгааны үр дүнг ХЭҮК-оос УИХ-д өргөн барьдаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлдээ тусгаж, бодлого, эрх зүйн чиглэлээр хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад хүргэсэн юм. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг бүрэн эхээр нь <https://bit.ly/2Tkeewd> -ээс үзнэ үү.

2017 оны 9 дүгээр сарын 15: СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ДҮН, ЗӨВЛӨМЖИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ УУЛЗАЛТ

ХЭҮК-оос судалгааны дүгнэлт, зөвлөмжийг УИХ-ын Тамгын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жендэрийн үндэсний хороо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холоо, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, МҮЭ-ийн холбоо, Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын тамгын газар зэрэг байгууллагуудын төлөөлөл, хуульчид, өмгөөлөгчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, их, дээд сургуулийн багш нар, хүний эрх, хөдөлмөрлөх эрхийн чиглэлээр үйл ажиллагаа

явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хэлэлцүүлэв.



2017 оны 12 дугаар сарын 06: “ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ БОЛОН ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ” ӨНДӨР ТҮВШНИЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ



ХЭҮК-той хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлийн асуудлаар нийгмийн түншлэлийн талуудыг оролцуулан “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл болон хувийн хэвшил дэх хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад оролцогчид ХЭҮК-оос хийсэн судалгааны үр дүнд түшиглэн Монгол Улсын нэгдэн орсон хөдөлмөрлөх суурь эрхийн талаарх олон улсын конвенциудын хэрэгжилт, хөдөлмөрийн харилцаанд гарч буй нийтлэг зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд шийдвэрлэх, хуулийг нэн даруй шинэчлэх шаардлагатай гэж үзэв.



Дэлгэрэнгүй үзэх:



<https://bit.ly/2RZwq1H>



<https://bit.ly/2PTkux5>




**2017 оны 12 дугаар сарны 06:
СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ТАРХААХ УУЛЗАЛТ**

ХЭҮК-оос судалгааны үрдүнгүг судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагууд, ажил олгогч, ажилтны болон төр, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан танилцуулж, цаашид хамтран ажиллахыг уриалав.



**АЖИЛ ОЛГОГЧИД, АЖИЛЧИД
БОЛОН ТЭДГЭЭРИЙН ТӨЛӨӨЛЛИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИЙГ
БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД**

GSP+1 2017-2018: Бизнесийн байгууллагуудад зориулсан “Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхийн хэрэгжилтийг өөрөө үнэлэх гарын авлага”-ыг боловсруулан гаргав.



Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Европын холбооны зах зээлд бараа бүтээгдэхүүнээ экспортолдог болон экспортлохоор зорьж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулан Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем, түүний ашиг тус, биелүүлэх нөхцөл, уг нөхцөлд багтдаг ОУХБ-ын суурь найман конвенцийн талаар мэдлэг олгох, эдгээр конвенцийн хэрэгжилтийг өөрийн байгууллагадаа үнэлэн сайжруулах арга хэмжээ авахад ашиглах гарын авлагыг боловсруулан гаргасан юм.

Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2B7oGjG>



**2019 оны 1 дүгээр сарын 29-30:
БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ХӨДӨЛМӨРИЙН
ХҮРЭЭНИЙ СУУРЬ ЗАРЧИМ, ЭРХИЙГ ХАНГАХАД НЬ
ЗӨВЛӨН ТУСЛАХ СУРГАГЧ БАГШИЙГ
БЭЛТГЭХ ЭХЛЭЛ ТАВИГДЛАА.**

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо ОУХБ-ын Ажил олгогч эздийн үйл ажиллагааны товчооны мэргэжил, арга зүйн дэмжлэгтэйгээр

экспортын баримжаатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхийг хангахад нь зөвлөн туслах сургагч багшийг бэлтгэх эхний шатны сургалт семинарыг зохион байгуулав. Энэхүү семинарын үеэр тус холбооноос гишүүддээ зориулсан ийм байнгын үйлчилгээ бий болгож хөгжүүлэх асуудлыг бусад орны туршлага дээр үндэслэн ярилцаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тодорхойлов.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2Tnlqre>



2019: Олон улсын хөдөлмөрийн суурь хэм хэмжээ

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос ажил олгогч эзэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулж ОУХБ-ын суурь найман конвенц, тэдгээрийг дагалдан гарсан зөвлөмжүүдийг эмхэтгэн гаргалаа. Эмхэтгэлийг www.monef.mn –ээс үзнэ үү.

Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2RuaVAY>



2018-2019:
АЛБАН БУС ЭДИЙН ЗАСАГТ АЖИЛЛАГЧДЫН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос албан бус эдийн засагт хөдөлмөр эрхэлдэг үйлдвэрчний эвлэлийн гишүүн, сонгуультнуудад зориулсан “Хөдөлмөрлөх эрх, суурь зарчим” цуврал сургалтыг зохион байгуулж, тэдний тулгамдаж буй асуудлуудаар санал солилцож, шийдвэрлэх арга замыг хэлэлцэв. Мөн оролцогчид албан бус эдийн засагт хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг хангуулах, ажиллагчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллыг сайжруулах талаар МҮЭ-ийн холбооноос явуулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлов.

2018 оны 11 дүгээр сарын 19-20

Аймаг, нийслэл, салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоодод харьяалагддаг албан бус эдийн засагт ажиллагчдын төлөөлөл оролцсон сургалт



Уг сургалтад хувиараа жижиглэн худалдаа, номын худалдаа, тээвэр эрхлэгчид, малчид, үсчин, гоо сайханчдын төлөөлөл оролцов.

Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2UqZDPH>



2018 оны 12 дугаар сарын 26

Нарантуул захын Хувиараа тээвэр эрхлэгчдийн үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороо, Бичил аян эздийн хоршооны гишүүдийг хамруулсан ажлын байрны сургалт



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2COV8Y6>



2019 оны 1 дүгээр сарын 3

Барилгачдын ҮЭ-ийн холбооны анхан шатны нэгж болох Байшин кранчдын нэгдсэн ҮЭ-ийн хорооны гишүүдийн сургалт



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2WoR211>



2019 оны 01 дүгээр сарын 14-15

Сэлэнгэ, Өмнөговь аймаг, нийслэл, салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоодод харьяалагддаг албан бус эдийн засагт ажиллагчдын сургалт



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2GbYWWJ>



2019 оны 01 дүгээр сарын 18

Хархорин захын худалдаа эрхлэгч ҮЭ-ийн хорооны гишүүдийг хамруулсан ажлын байрны сургалт



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2sRIKdf>



2019 оны 1 дүгээр сарын 18

Албан бус эдийн засагт ажиллаж буй үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн оролцоотойгоор боловсруулсан “МҮЭ-ийн холбооноос албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн суурь эрхийг дэмжих чиглэлээр 2019-2021 онд явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг аймаг, нийслэл, салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоодын төлөөлөгчид хэлэлцэж, саналаа тусгав.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2MEzj1H>



МҮЭ-ийн холбооноос 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан энэхүү төлөвлөгөөнд албан бус эдийн засагт ажиллагчдыг төлөөлсөн үйлдвэрчний эвлэлийн байгууллага, бүтцийг бэхжүүлэх, ажиллагчдыг эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нийгмийн зөвшлийн хүрээнд тэдний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх, МҮЭ-



ийн холбооноос албан бус эдийн засагт ажиллаж буй гишүүдийнхээ эрэлт, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хөгжүүлэх, сургалт, мэдээлэл, зөвлөгөөг өргөжүүлэх зэрэг асуудлыг тусгасан байна.

Уг төлөвлөгөө болон албан бус эдийн засагт ажиллагчдын хөдөлмөрлөх суурь эрхтэй холбоотой бусад мэдээллийн товхимолыг <https://bit.ly/2SRQovE> –ээс үзнэ үү.



2018: ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙГ ДЭМЖИХ КАМПАНИТ АЖИЛ

ХЭҮК-оос 2017 онд хийсэн “Жижиг, дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа, үйлчилгээ, ноос, ноолуурын салбар” сэдэвт судалгаагаар илэрсэн хөдөлмөрлөх эрхийн зөрчлүүд нь зарим талаар хөдөлмөрийн харилцааг зохицуулсан олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжийн талаарх ажил олгогч, ажилтнуудын мэдлэг, ойлголт хангалтгүй байгаатай холбоотой гэсэн судлаачдын дүгнэлтээс үүдэн МҮЭ-ийн холбооны Залуучуудын хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар(ГБХЗХГ)-ын харьяа Сургалт, судалгаа, мэдээллийн төв хамтран залуучуудын хөдөлмөрлөх эрхийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд хамтран ажиллах санаачилга гаргасныг төслийн хүрээнд дэмжиж ажиллав. Үүний үр дүнд энэхүү санаачилга нь “Залуучуудын зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний сүлжээ” болж өргөжив.

Залуучуудын зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний сүлжээ

Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2RShZfw>



2018 ОНЫ 5 ДУГААР САРЫН 9-10: “ЦАХИМ СҮЛЖЭЭНД НӨЛӨӨЛЛИЙН КАМПАНИТ АЖИЛ ӨРНҮҮЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙ” СЭДЭВТ СУРГАЛТ

МҮЭ-ийн холбооны Залуучуудын хорооноос зохион байгуулсан уг сургалтад сүлжээнд нэгдсэн байгууллагуудын төлөөлөл 26 залуу оролцож, зохистой хөдөлмөрийн үзэл баримтлал, хөдөлмөрлөх эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг цахим сүлжээг ашиглан түгээх, залууст үр дүнтэй хүргэх аргад суралцав.




Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2UoVAn6>



2018 оны 5 дугаар сарын 15-16: Залуучуудад хөдөлмөрлөх эрхийн мэдлэг олгох, түгээх чиглүүлэгчдийг бэлтгэв.

МҮЭ-ийн холбооны Залуучуудын хороо, ГБХЗХГ-аас хамтран зохион байгуулсан “Залуучуудын хөдөлмөрлөх эрхийн чиглүүлэгч бэлтгэх сургалт”-д сүлжээнд нэгдсэн байгууллагуудын төв, орон нутгийн салбаруудыг төлөөлсөн залуучууд хамрагдав. Сургалтыг ОУХБ-ын болон үндэсний мэргэжилтнүүд хамтран удирдаж явуулав.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2RoSCg9>



Бэлтгэгдсэн чиглүүлэгчид цаашид хөдөлмөрлөх эрхийн мэдлэг түгээх сургалт явуулахад нь зориулж ОУХБ-ын “Залуучуудын хөдөлмөрлөх эрх: Залуучуудын зохистой хөдөлмөр (Чиглүүлэгчийн гарын авлага ба хэрэглэгдэхүүний багц)” номыг орчуулж хэвлэв.

Дэлгэрэнгүй үзэх:



<https://bit.ly/2WsEHcM>



<https://bit.ly/2G8sNz1>

2018 оны 6-9 сар: Чиглүүлэгчдийн баг Улаанбаатар, Дархан-Уул аймагт 500 орчим залууст хөдөлмөрлөх эрхийн сургалт явуулав.

2018 оны 6 дугаар сарын 11-12: Дархан-Уул аймгийн ГБХЗХГ, ҮЭ-ийн холбоо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар(ХХҮГ)-тай хамтран албан ба албан эдийн засагт ажиллагч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч болон ажил хайж буй 375 залууг сургалтад хамруулав.



Ажил идэвхитэй хайгч залууст зориулсан сургалт



“Дархан Дулааны Сүлжээ” ТӨХК дээр хийсэн сургалт





“Дархан Төмөрлөгийн үйлдвэр” ХК дээр хийсэн сургалт



Хувиараа бизнес эрхлэгч залууст зориулсан сургалт



“Дархан Минж” ХХК дээр хийсэн сургалт



ҮЭ-ийн идэвхтэн, сонгуультаан залууст зориулсан сургалт



“Элит Хөгжил” ХХК дээр хийсэн сургалт

Энэ явцад Дархан-Уул аймгийн ГБХЗХГ, аймгийн ҮЭ-ийн холбоо болон ХХҮГ-ын дарга нар залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрхийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурснаар “Залуучуудын зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний сүлжээ”-ний үйл ажиллагаа орон нутагт тэлэх эхлэл тавигдав.




2018 оны 06 дугаар сарын 22 – 9 дүгээр сарын 27: Улаанбаатар хотод СХД-ийн ГБХЗХХ, Монголын Залуучуудын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран хувийн хэвшлийн зарим томоохон аж ахуйн нэгжийн ажилтнууд, ажил хайгч болон хувиараа, албан бусаар хөдөлмөр эрхлэгч 130 залууг сургалтад хамруулав.



Монголын Залуучуудын холбооны дэргэдэх Хөдөлмөрийн төв биржтэй хамтран ажил хайж буй оюутан залууст хийсэн сургалт (2018.06.14)

“Залуучууд: Хөдөлмөрлөх эрх” залуучуудын хөдөлмөрлөх эрхийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чилгэсэн кампанит ажлуудын видео”-той <https://bit.ly/2DI6SNK> –ээс танилцаарай.





Сонгино Хайрхан дүүрэгт байрладаг ТЭСО корпораци, Сүү ХК, Алтан тариа ХХК-ийн залуу ажилтнуудын сургалт (2018.06.26)



Дүнжингарав худалдааны төвд албан бус, хувиараа хөдөлмөр эрхлэгч залууст зориулсан сургалт (2018.09.27)


Залуучуудын хөдөлмөрлөх эрхийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн материал



ГБХЗХГ-ын харьяа Сургалт, судалгаа, мэдээллийн төвөөс залуучуудын дунд “Зохистой хөдөлмөр миний төсөөллөөр” постерын уралдаан зарлан дүгнэж, бэлтгэгдсэн багийн гишүүдтэй хамтран залуучуудад зориулсан хөдөлмөрлөх эрхийн гарын авлага,

хөдөлмөрийн хууль, зохистой хөдөлмөр, нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх видео контент, социал медиа постерууд боловсруулж түгээх ажлыг зохион байгуулав.

“Та зохистой хөдөлмөр эрхэлж чадаж байна уу?” харандааны адал явдалтай <https://bit.ly/2sRHHt> –ээс танилцаарай.




“Хөдөлмөрлөх эрхээ мэдье, хэрэгжүүлье” залуучуудад зориулсан гарын авлагыг <https://bit.ly/2NjKx0C> –ээс үзнэ үү.

“Нийгмийн даатгал таны насан туршийн баталгаа” харандааны адал явдалтай <https://bit.ly/2SSjU4r> –ээс танилцаарай.



“Хөдөлмөрийн гэрээ” сэдвийн хүрээнд залууст тулгардаг түгээмэл асуултуудын хариу видеог <https://bit.ly/2Gck74X> –ээс үзнэ үү.



ХӨДӨЛМӨРИЙН ХҮРЭЭНИЙ СУУРЬ ЗАРЧИМ, ЭРХҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХАД ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

2017 оны 5-6 сар:

Төслийн хүрээнд ОУХБ-ын Турин дэх Олон улсын сургалтын төвтэй хамтран Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монголын хуульчдын холбоо, UB post сонины төлөөллийг Италийн Турин хотноо “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ” сургалтад хамруулав.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2UjHqn0>



GSP+1 2017 оны 8 дугаар сарын 21-25: Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний асуудлаар шүүгч, хуульч, сургагч багш нарыг сургав.

Шүүхийн практикт хөдөлмөрийн маргааныг хянан шийдвэрлэхдээ олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг зохистой ашиглахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын хуульчдын холбоо, ОУХБ-ын Турин дэх Олон улсын сургалтын төвтэй хамтарсан сургалтыг хуульч, шүүгч, сургагч багш нарт зориулан Улаанбаатар хотноо зохион байгуулав.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2Ba8uy2>




2018-2019:

Олон улсын хэм хэмжээний талаар хуульчдад зориулсан цуврал видео хичээлийг боловсруулан гаргав.

Монголын хуульчдын холбооны гишүүдэд өмнө зохион байгуулсан сургалтуудын мөрөөр тус холбооны Хөдөлмөрийн эрх зүйн дэд хороотой хамтран албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлт дэх ялгаварлан гадуурхалтыг устгах, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг шүүхийн практикт хэрэглэх нь сэдвээр 4 төрлийн видео хичээлийг боловсруулан гаргалаа.

“Албадан хөдөлмөрийг устгах талаарх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ”



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2Uo9lCr>



“Хүүхдийн хөдөлмөрийг устгах талаарх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ”



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2UjJgnU>



“Хөдөлмөр эрхлэлт, ажлын байран дахь адил тэгш боломж олгох асуудлаарх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ”



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2G8Esy3>



“Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг шүүхийн практикт хэрэглэх нь”



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2SPeXZX>



2018: ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН АНХАН ШАТНЫ ЗӨВЛӨГӨӨ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ӨГӨХ ЦАХИМ ХУУДАС

Монголын хуульчдын холбооноос иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор хөдөлмөрийн болон бусад асуудлаар эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх цахим хуудсыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Иргэдийн асуултад тус холбооны гишүүн хуульч, өмгөөлөгчид хариу өгдөг энэхүү цахим хуудас руу www.legalaid.mglbar.mn холбоосоор зочилно уу.



2018 ОНЫ 6 ДУГААР САРЫН 27-28: ШҮҮГЧ, ПРОКУРОР, ӨМГӨӨЛӨГЧ НАРТ ЗОРИУЛСАН АЛБАДАН ХӨДӨЛМӨР, ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АСУУДЛААРХ СУРГАЛТ



Монголын хуульчдын холбооноос шүүгч, прокурор, өмгөөлөгч, гишүүн хуульчдын олон улсын хөдөлмөрийн эрх зүйн талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэх, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэглэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор ОУХБ-ын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулав.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2sXjMAZ>



2018 оны 6 дугаар сарын 29: Хүүхдийн эрхийн болон хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалт


ГБХЗХГ болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран “Хүүхдийн хөдөлмөр ба албадан хөдөлмөр” сургалтыг ОУХБ-ын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, нийслэл, орон нутгийн хүүхдийн эрхийн болон хөдөлмөрийн хяналтын улсын 72 байцаагчийг хамруулав. Сургалтын явцад хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн талаарх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, үндэсний хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудыг ярилцсаны зэрэгцээ хүүхдийн хөдөлмөрийг устгах талаарх олон улсын сайн туршлага, онлайн сургалтын модулийг танилцууллаа.



Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2RIDWOV>



2018: Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль тогтоомжийн эмхэтгэл




ГБХЗХГ-аас хүүхдийн эрхийн болон хөдөлмөрийн хяналтын байцаагчид, бусад холбогдох ажилтнууд, аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулж хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль тогтоомж, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, үндэсний стандарт, зөвлөмж зэргийг эмхэтгэн гаргалаа.

Дэлгэрэнгүй үзэх:
<https://bit.ly/2CROiTi>



GSP+ ба хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрх



Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтын хэлэлцээ хийх эрхийг бодитой хүлээн зөвшөөрөх

Албадан хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах

Хүүхдийн хөдөлмөрийг бүрмөсөн устгах

Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд ялгаварлан гадуурхалтыг устгах



📍 ОУХБ-ын Монгол дахь Үндэсний зохицуулагчийн газар
НҮБ-ын байр 209
Нэгдсэн үндэстний гудамж 12
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар 14201, Монгол улс

☎ 976-11320624

✉ ulaanbaatar@ilo.org

🌐 www.ilo.org

📘 [decentproductivework](https://www.facebook.com/decentproductivework)

🐦 twitter.com/ilo_mongolia

📺 [www.youtube.com/ilo tv mongolia](https://www.youtube.com/ilo_tv_mongolia)

